

Захчин (Жахачин¹) хошууны Өлзөй цагаан Бадма номлол бүтээл
өргөн дэлгэр² хийдийн³ жасын⁴ тухай

Д. Кара, Ж. Цолоо

Монгол улсын Ховд аймгийн Манхан, Зэргэ, Алтай, Үенч суманд Хутагтын⁵ гэгээний⁶ хүрээ⁷, Гүн⁸ толгойн хүрээ, Төгрөгийн хүрээ, Үенчийн хүрээ, Хойт эхний хүрээ гэдэг хийдүүд⁹ байжээ. 1680-аад оны сүүлчээр Зүүн гарын хаант улсад байгуулсан Ойрадын шашны цанид¹⁰ дацанг¹¹ Монгол нутагт сэргээж 1762 онд захчин хошууны Үенчийн голд¹² шилжүүлж төвхнүүлэн тогтоов. Энэ хийдийн монгол нэр Өлзөй чухаг давхарлагсан¹³ болно.

Дацан сүмийн¹⁴ Зуу шүтээ нь¹⁵ цагаан мөнгөөр эгүдэгсэн дээд цагаан охийн¹⁶ магтаалт хутагт¹⁷ равжим¹⁸ зая бандида¹⁹ Намхайжамцын дүр мөнгөн бурхан юм. Хутагтын гэгээн Намхайжамцын номлосон сургаал, номын үйлсийг Захчин хошуунд дэлгэрүүлж тасалдсан хурал, хийдийг сэргээж долоон шинэ дацан тогтоов. Гэр дугантай²⁰ нүүдлийн энэ хийдийг Хутагтын гэгээний хүрээ гэдэг байжээ.

Энэ хүрээ бол Зүүн гар улсын нутгаас Захчин отог хушуу дүрвэж явсаар одоогийн нутагтаа ирээд тогтоосон эхний хийд юм. Захчины хошуу захиргаа, гүн ноёны тамгын газар, энэ хүрээтэй хамт байсан учир Захчин гүнгийн хүрээ²¹ гэж нэрлэж, бичих болов. Сүүлд *Ölzöi sayān Badma nomlol бүтэл örgön delger sūme*²² хэмээх томоохон цанид дацанг 1906 онд босгосон юм. Энэ бол Захчинд байгуулсан долоодахь дацан юм. Уул дацангийн дэргэд Зонхавын²³ хэмээх шашин хурлын сан²⁴ 1906 оны есөн сарын 3-нд тогтов. Чойрын сан жасын эрхин шүтээн нь Зүүнгар улсад шүтэж байсан орд (урт) олбог²⁵ жанчтай²⁶ мөнгөн Зонхав бурхан²⁷ [... Алтан эрхэн ... Debter 12, 1997:140. Budapest.] юм.

Жасыг үүсгэгчид нь Ойрад-захчины үндсэн ламтаны²⁸ V хувилгаан²⁹ дүр Данзанчинрэвжамц = Чинрэв гэгээнтэн (1875 – 1941), бэйс³⁰ ноён Цэрэндорж = Андиа гүн (1845 – 1912–13), энэ цанид дацангийн эх туурвил шажны тоолбор «Шажны алтан нарны гэрэлийн нилчийг тогтоон өгүүлэгсэн Өлзөй Цагаан Бадма номлол бүтээл өргөн дэлгэр сүмийн эхэ туурвил Алтан эрхэн хэмээх оршивой» номын зохиогч Чойр жасын тахилч лам агсан умзад³¹ гэлэн³² Чойсамбуу (Дармабадра) үеэл омбу³³ Ломпэл нар тэргүүлсэн 60-аад өглөгийн эзэд³⁴ болно.

1. **Зонхава чойр жасын мал.** Бүгд 1605 толгой бог, бод мал. Адуу 105, тэмээ 40, монгол үхэр 42, сарлаг 112, хонь 1130, ямаа 181, жасын хөрөнгө хогшил: Ачаалах тэмээний тоног хэрэгсэл: кэлкээ, кэрээ³⁵ аргамж 20, бурантаг³⁶ 35, буйл³⁷ 30, зэл³⁸ 1, заасаа шат³⁹ 2, бамбай⁴⁰ 4.

2. **Гэр өргөөний зүйл.** Гэрийн бүрээс, тавилга, багаж зэмсэг. Шангийн өргөө⁴¹ 1 (бүрэн гүйцэд тавилгатай), бурханы өргөө 1, хуралын өргөө 1, арван тэрэмт⁴² 1, зургаан тэрэмтэй гэр нэг, жисааны өргөө гэр нэг, дугдум⁴³ нэг, эсгий бүрээс хоёр, бөс хөшиг зургаа, задгай хөшиг нэг, битүү хөшиг нэг, эсгий тойруулган дэвсгэр нэг, эсгий ширдэг арван найм, хивс дөрөв.

3. **Сав суулга, багаж зэмсэгийн зүйл.** Авдар найм, үхэг⁴⁴ нэг, тавиур⁴⁵ нэг, ширээ зургаа, тулга гурав, тогоо гурав, есөн тамгат⁴⁶ тогоо⁴⁷ нэг, шанага дөрөв, халбаг нэг, заазуур дөрөв, зуух⁴⁸ нэг; таван хайч, хоёр хусуур, гурван хүрз, гурван сүх, хоёр хөрөө, хоёр хадуур, нэг ширбүүл⁴⁹, зургаан цоож, арван таван аяга⁵⁰, дөрвөн таваг, зурган дийз⁵¹, нэг суулга, дөрвөн домбо⁵², хоёр күв⁵³, нэг жигнүүр, нэг ваар⁵⁴, гурван чүүгэн⁵⁵, нэг архад⁵⁶, арван гурван уут⁵⁷, хоёр дүнкүү⁵⁸, хоёр шуудаа⁵⁹, нэг хошуу⁶⁰, боорцогны нэг тамга⁶¹, нэг дурам⁶².

4. **Бөс, даавуу торгоны зүйл.** Дөрвөн торго, гурван чисчүү⁶³, дөрвөн даалимба, долоон даавуу, нэг ваадан⁶⁴, хоёр бороон⁶⁵, нэг шилкэв⁶⁶ солонгын торго, нэг шамбын⁶⁷ ногоон торго, нэг улаан шамбу.

5. **Цай, идээ, будааны зүйл.** Хоёр сэвэг⁶⁸ цай, нэг ширхэг цай, 1100 жин⁶⁹ гурил, 30 тогоо будаа, 7 тогоо тутрага, 80 жин гоймон⁷⁰, 20 жин үзэм, 100 жин тосон, 119 тогоо тариа.

6. **Алт, мөнгөний зүйл.** 50 лан⁷¹ ембүү⁷².

7. **Хадаг, самбааны зүйл.** Дөрвөн зах⁷³ их хадаг, арван зах бага хадаг⁷⁴, таван зах самба⁷⁵.

8. **Хүж, үнэртний зүйл.** Урт ахар таван бааз⁷⁶ хүж, нэг багз хүж⁷⁷.

9. **Бурхан шүтээн.** Суумал (цутгамал) бурхан; хутагтын гэгээн⁷⁸ нэг; нэг Зонхав⁷⁹; нэг Ямандаг⁸⁰, Зүүн гар Ойрад улсын анхны цанид дацангийн эрихин шүтээн, нэг Зонхав бурхан жанчи⁸¹ жинкэв нээрэнтэй⁸², Зүүнгар улсын анхны Зонхав жасын шүтээн Зонхав мөнгөтэй орд (урт?) олбог жанчтай нэг, нэг Майдар⁸³ бурхан; суух⁸⁴ бурхан дөрөв, үндүсүн ламтаны IV хувилгаан дүр Наваанлуvsанжамбалын (1853–1873) шарилын⁸⁵ алтан суврага нэг.

10. **Хөрөг бурханы зүйл.** Намхайжамц Хутагтын гэгээний хөрөг⁸⁶ бурхан нэг; Махгалын⁸⁷ хөрөг нандиртай⁸⁸ нэг; Сэнгдонгмын⁸⁹ хөрөг нэг; есөн төө⁹⁰ лагшинтай⁹¹, есөн тохой⁹² захавчтай Майдар гэгээний хөрөг нэг; Манжуширийн⁹³ хөрөг нэг; Лхам⁹⁴ нөхөд сэлтийн дэлгэр хөрөг нэг; Дара эхийн⁹⁵ хөрөг нэг; гүн мкйан ламын⁹⁶ хөрөг нэг; Аминдаваа⁹⁷ бурханы хөрөг нэг; Мил оточийн⁹⁸ хөрөг нэг; танга⁹⁹ арван дөрөв; арван зургаан бат орны¹⁰⁰ хөрөг гурав; арван зургаан бат орны ёст мод нэг.

11. **Бурханы тахил, чимэг, зүүлт тавилга, хөгжим зэмсэгийн зүйл.** Нэг зэс гавал¹⁰¹, нэг мөнгөн гавал, гүштэй¹⁰² бумба¹⁰³ нэг, дээжийн домбо хоёр, тахилын цөгц¹⁰⁴ нэг зуун тавин долоо, нэг мөр¹⁰⁵ цөгц, зүлын цөгц хорин ёс, байтун¹⁰⁶ цөгц хоёр, Голт¹⁰⁷ хоёр, цөгцийн ширээ хоёр, Мандалын¹⁰⁸ их ширээ хоёр, сэргимтэй¹⁰⁹ мөнгөн цөгц нэг, тахилын мод дөрөв, нэг мандаа¹¹⁰ суурь¹¹¹ дөрөв, таван морин ширээ, дөрвөн чимэг, таван лабрэ¹¹², ухиалын хэрэгсэл бүрэн, гурван жанч, гурван номт хувцас¹¹³ гүйцэд, хорин таван олбог, хоёр хивсэн олбог, хоёр талбаг¹¹⁴, нэг хивсэн талбаг, түшлэг¹¹⁵ тав, торгон түшлэг нэг, гадар олбог дөрөв; бүрээ¹¹⁶ нэг, бишгүүр¹¹⁷ нэг, хонх¹¹⁸ хоёр, дaмap¹¹⁹ хоёр, цан¹²⁰ тав, дун¹²¹ дөрөв, гангли¹²² нэг, хэнгэрэг¹²³ дөрөв, очир хонхо¹²⁴ нэг; их жалчин¹²⁵ тав, хийморийн¹²⁶ жалчин нэг, шасэр¹²⁷ гурав, цондогийн¹²⁸ хивсэн бүрээс, эркэн¹²⁹ нэг, бангкэв¹³⁰ нэг, шилнэн¹³¹ нэг, хорол¹³² нэг, шүхэр¹³³ нэг, цэцэг¹³⁴ нэг, алтан мигтар мигман с[а]та¹³⁵ нэг, дингкэв¹³⁶ тав, нийдан¹³⁷ кан¹³⁸ бүрээстэй

хоёр, пан¹³⁹ хоёр, лонх нэг, мандай нэг, бүтээлэг бөс нэг, дугдум нэг, хөвөнгийн хайрцаг нэг, хүжийн хатгуур нэг, баг ниндартай¹⁴⁰ нэг, урт ниндар гурав, богино ниндар найм, чойжил¹⁴¹ сахиусан гэгээний баг нэг, ниндир гангтай¹⁴² гүйцэд, бурханы хайрцаг¹⁴³ нэг, шилкэв хоёр, канжай¹⁴⁴ гурав, вкшох¹⁴⁵ гурав, ширээнүүд¹⁴⁶, тавжуур¹⁴⁷.

12. Тариалангийн орам¹⁴⁸ талбай, үрс. Энэ их жасад нэр бүхий арван хүн өрсдийн эзэмшлийн тариалангийн орам газраас хорин дөрвөн тогоо тариа тариалах орам, тариг¹⁴⁹ хандивлаж өглөгийн эзэн болжээ. Зонхавын жас одоогийн Үенч сумын нутаг Цагаан бураад зургаан тогоо тариа, Даваатын аманд долоон тогоо тариа, Хар хадад зургаан тогоо тариа, Жиргалантын шар бэлчэрт гурван тогоо тариа, Модон овоод арван тогоо тариа тариалах хэмжээтэй жасын эзэмшил газар ангис орамтаа байжээ: Мөн хорин хоёр тогоо тарианы үрсийг өглөгийн эзэд жасад өргөж буян үйлджээ.

13. Идээ, ундаа; тахил. Шашны хурал номын ламнарт цай хоол цав¹⁵⁰, манз¹⁵¹, өргөл барьц түгээл зэд¹⁵², ном сударууд усан тахил өргөж чойрын жасыг Захчин отог хошуугаараа тогтоожээ.

¹ Mong. *jaqačin*; oir. *jaxačin*; Захчин: Монгол улсын Ховд аймагт оршин суудаг, 20000 гаруй мянган хүн ам бүхий, Ойрад угсааны нэгэн ястан. Эрдэмтэд Зүүн гар Ойрадын хаант улсын зүүн, зүүн өмнөт зах харуулыг сахин хамгаалж суудаг байсан хязгаарын цэргийн хошууг захчин *jaqa* + *čin* юм гэжээ. Алтай сумын Балхааны Чинрэв, Манхан сумын Адуучийн Түмэн-Өлзий, Жуурайн Ванчиг нар *jaqa-a-yin čino-a* «захын чоно» гэдэг үгийн сунжирсан дуудлага гэж 1963 онд хуучлав; *džaxtšin*, *dzaxtšin* Dz D.Ка. 136; *zax^htšin*, хил хязгаараар оршин суугчид RKWb, 464.

² Tib. *bkra-shis pad-dkar bshad-sgrüb dar-rgyas-gling*. Дашбадгар – шаддув – даржай – лин. (АЕ, 4, 5, 91, 169).

³ Mong. *keyid*; oir. *kiyid*, *kīd* «хүрээ хийд» RKWb, 234. О. Сүхбаатарын бодлоор < skr. *kṛeta* ламнарын хуран суух орон, сүм; гэвч дунд эртний монгол хэлний *kebid* гэсэн хэлбэр эл бодлыг дэмжихгүй.

⁴ Mong. *jisa*; oir. *jisa* < tib. *spyi-sa*, нийтийн газар, олны өмч; Сүм хийдийн мяндагтан ламнарын аж ахуй: *džisān*: «ээнт улс эмх цэгц, журам; дэс дараа» RKWb 113; Ков. III, 2337а общее достояние «нийтийн орлого». XX зууны эхэнд Монгол улсын бүх хүрээ хийд нийтдээ 700 орчим жастай байв. С. Пүрэвжав: *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*. 1978 Улаанбаатар; 135.

⁵ Mong. *qutuqtu*; oir. *xutuqtu* [150.52] ариун сахилтан, шашны ёсны сахилтан; нандигнах сүм, хийд, бурхны хөрөг баримлыг ариусган амилуулагч, ариутгагч; *qutuq*. tü. *qut* амар жаргал, жаргал цэнгэл; сүр жавхалант хан; tü. *kutu*, жаргалан, аз жаргал RKWb 200;]

⁶ Mong. *gegen*, *gegegen*; oir. *xutuq-tuyin gegēn* [148]; *xutuq=tuyin gegē* [156]; *gegēn* өдрийн гэрэл гэгээ, гэгээн; тунгалаг, саруул, цэлмэг: [*gegen*, **gegegen*, *geyi-* (> *gi-*) > *ma. genggiyen* RKWb 132, 134].

⁷ Mong. *qutuqtuyin gegen-ü küriy-e*; 1640 онд тод – монгол үсэг зохиож, төвдийн хэлнээс бурханы шашны 180-аад ном (монголчилон) орчуулж, дөрвөн Ойрадад шарын шашны сургаал, номлолыг дэлгэрүүлсэн. Ойрадын ном бичгийн хэлийг үндэслэгч Монгол улсын шашин, төрийн нэг нэрт зүтгэлтэн соён гэгээрүүлэгч хутагтын гэгээн Намхайжамц = Огторгуйн далайн (1599–1662) хүрээ; *küriy-e*, Oir. *kürē* «байрин суурин газар».

⁸ Mong. *güng*; oir. *güng*; < chin. *gōng* (tib. *gung*) 1. феодалын байгуулалын таван хэргэмийн тэргүүн зэрэг (Я. Цэ. 165); 2. Манж чин улсын үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн дөтгөөрх нь (О. Сүх. 70); *ma. gong*, ванг, эзэн, ноён. Захчин хошууны Үенч, Алтай сумын нутагт Хөх толгойд 1762 (хар морин жил) Захчин гүн Жамцан тогтоосон Өлзөй чухаг давхарлагсан хийдийг (АЕ, 86, 87) гүн толгойн хүрээ гэдэг.

⁹ Б. Ринчен: *Монгол Ард улсын угсаатны суудал, хэлний шинжлэлийн атлас*. Улаанбаатар, 1979.

¹⁰ Mong. *čanid*; oir. *tchan-ñid* < tib. *mtshan nyid* «бэлгэ чанар».

¹¹ Mong. *dačang*; oir. *grv[a]-cang*; *daching* [132, 134]; tib. *grwa chang* «хуврагийн аймаг; цанид дацан *čanid* *dačang*; < tib. *mtshan nyid grwa chang* [130], аливаа юм үзэгдлийн билэг чанарыг судлах шашны - гүн ухааны сургууль.

¹² Namtar bolai; Á. Birtalan: *Geschichte der Heiligen Götterbilder der Drei Klöstör Unseres der Jaqačin-Volks*. АОН 1985, pp. 178-191; АЕ, 87.

¹³ Tib. *Bkra-shis dkon-brtsegs gling*. (АЕ, 86, 87)

¹⁴ Mong. *süm-e*; oir. *süme*; шашны ёсны зан үйл үйлдэх ерон байр; *sümü tsondzi* RKWb, 340.

¹⁵ Mong. *juu sitügen*; oir. *zuu sūtēn* [...153...] < tib. *jo-jobo* «эзэн богдос, дээдэс». 1. бурханы хөрөг дүрс; хөрөг, бурхан; 2. шарын шашны том зүтгэлтэн; *zū sūtān*, итгэл, найдвар; сүм RKWb, 372, 482.

¹⁶ Mong. *degedü čayan oki*; oir. *dēdū čayān oki-yin maqtāl* < tib. *tog dkar* «үзүүр оргил цагаан».

¹⁷ Mong. *qutuqtu* – 7-р тайлбар үзнэ үү.

¹⁸ Oir. *rabjamba, rabjum, rabjama* < tib. *rab'byams pa*; «маш хэтэрхий; их эрдэмтэн»; Төвдийн Гумбум хийдийн гүн ухааны дацангаас олгож байсан эрдэмийн дээд зэрэг. Намхайжамц, цанид хэмээх гүн ухааны талаар маш хязгааргүй «равжамба» цол хамгаалахдаа нэг ч үг эс алдсанд бүгдэд гайхагдаж алдар нэр нь дуурисав.

¹⁹ Mong. *jay-a* ~ *jay-a*; oir. *jaya* < tib. *dzaya*; (< skr. *jaya* «ялгуусан»; бүрэн алдаршсан, төгс ялсан; mong. *bandida* < skr. *paṇḍita* «ухааны таван орон буюу учир шалтгааны ухаан, дуун ухаан, тэжээх ухаан, урлахуй ухаан, дотоод ухаанд мэргэжсэн хүнд олгож байсан ном эрдэмийн цол «сайтар ялгуусан».

²⁰ Mong. *duyang*; oir. *duyang, duyung* < tib. *'du-khang* «хурлын байшин». Дуган нь их төлөв хоёр эгнүүлсэн баганаар тусгаарлагдах гурван хэсэг бүхий нэг өрөө; 7-р тайлбарыг нэмэж уншина уу.

²¹ 8-р тайлбарыг үз.

²² 2-р тайлбараас төвд нэрийг сэргээн уншина уу.

²³ Номын дацангийн сан; mong. *zonggaba*; oir. *jongkapa* [...140...] – *yin jisa* < tib. *tsong kha* ~ *tsong-kha pa* «Сонгинотын ам»: Гэлугбаа нарын сургуулийг үүсгэсэн, шарын шашны их багш Лувсандагва нь 6-р равжунгийн улаагчин тахиа жил (1357) Хөх нуурын Гүмбүм хавьд байдаг Зон ха буюу «Сонгинотын ам» гэдэг газарт төрсөнөөр түүнд хайрласан нэр.

²⁴ Mong. *sang*; oir. *sang*; < chin. *cang*; «хутагт нарын хувийн аж ахуй».

²⁵ Mong. *olbuq*; oir. *olboq* [149,150] суух дөрвөлжин дэвсгэр; *olwag*; [*olbag*; kkir. *olpoq*, хуяг?] RKWb. 285.

²⁶ Mong. *jingci* ~ *jangca*; oir. *jangci* [149]; ma. *jangci* «ламнарын нөмрөх олон хуниастай хувцас». Ков. III 2241a «мангтя, плаш (без воротника и рукавов)».

²⁷ Зонхов Лувсандагва богдыг (1357-1419) Зүүн гар улсын үеэс Ойрад Захчины сүм хийд жасад уламжлан шүтэж байгаад Улаанбатырын Гандан хийдэд шилжүүлэн тахив.

²⁸ Oir. *ündüsün blamatan* [97,126,114] < tib. *rgund-kyi ston-pa* «үндсэн гол багш».

²⁹ Mong. *qubilyan*; oir. *xubilyān* [...89...] *rinbuči* < tib. *rin po che* «их эрдэнэ» Бурхны шашинтны тодорсон эрдэмт хувилгаан. Амьтныг зовлонгоос аврахын тулд орчлонд хүний дүрээр хувилан төрсөн бурхан, дахин төрөөд байдаг шидтэн.

³⁰ Mong. *beyise*; oir. *beyise*; < ma. *beise*. Манж, Богд хаант улсын үед монголын ноёдын хэрэглэж байсан хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр зэрэг.

³¹ Mong. *umjad*; oir. *dbumzad, umzad* [135,149] < tib. *dbu mdzad*; «эхлэн зохиогч». Шашны хурлын уншлага уншихад дагуулан уншигч, аргил буюу бүдүүн (итали. *baritono*) хоолойтой лам.

³² Mong. *gelüng*; oir. *dgeslong, gelüng*; < tib. *dge slong* (skr. *bhikṣu*) «буян сэдэх». Бурханы шашны ёсны нэгэн зүйл санваар. Ламын ёсонд байсан гурван сахилын хамгийн хатуу нь. Буян сэдэх тухай багшийн өмнө авсан гутгаар амлалт (О. Сүх 74).

³³ Mong. *ombu*; oir. *ombo* [...138...]; < tib. *dbon po* «үеэл».

³⁴ Mong. *jinday*, oir. *öqligiyin ezen* [...153] < tib. *shyin bdag* (skr. *dhānapati*) «өглөгийн эзэн». Өглөг өгч хүндэлж байх хүн. Өглөгийн эзэн гурван зүйл өглөг өгнө. Эд агуурсаны өглөг (хүнд эд бараа, мөнгө зоос өгөх), номын өглөг (номын мөр ёсоор явахыг хичээлгэх); үл айхын өглөг (аюул гамшигт учирсан буюу сэтгэлд нь аймшиг төрсөн хүнийг түүнээс нь зайлуулж тус хүргэх) эдгээр болно. (О. Сүх 99-100); «өргөл барьц, бадар хандив» ард олон шашны алба залгуулах шар феодалын албан гувчуурыг (Д. Гон. 1964: 225) цайруулсан нэр томъёо.

³⁵ Mong. *qoos*; oir. *kelkei, kerei, kerē* [164]; гурван хос аргамж: *xom amyaldza*: хом баглаж бэхлэх аргамж; *tendzā amyaldza* ачаа тэгнэх аргамж (оосор, сур, хошлон, олс); *ekē amyaldza*: татлага аргамж, ачсан ачааг бэхэлж хүлэх бөх аргамж; *aryamji* аргамж; *amyaldza* D.Ка. *amyaldzi, armldz, aryamdzi*; [*aryamji* > karg. *aryantu*; kas. kir. *arqan*, ar- нэхэх RKWb. 13].

³⁶ Mong. *buruntay*; oir. *burantaq* [164] тэмээний буйлны зөв үзүүрээс уяж тэмээ хөтлөх, уяж нарийн дээсэн оосор; *burntüg* [*buruntug* < tü. *burun* хамар] RKWb. 62; *Xamār Dz.T.U.* «бурантаг».

³⁷ Mong. *buyila*; oir. *buuli* [164] тэмээний хамрыг буруу талаас нь нүхэлж хөндлөн тогтоосон бурантаг уяж ац бүхий мод. Буруу талдаа ацтай, зөв үзүүр нь товх бүхий; *bül'* D.Ка. 131; [*büli* > kir. *büidö, buida*] RKWb. 62, 64.

³⁸ Mong. *jele*; oir. *zel* [137] тугалын зэл, унаганы зэл, ботгоны зэл, гүүний зэл: *zelē* [kkir. alt. *jelü*, kir. *zeli*] RKWb. 472; хурга, ишигийг гэрт, гадаа, уяж торгох зэлийг көнгөнө (*köññä*), *kögen-e, kögöne* гэдэг.

³⁹ *zāsa šata* [164] Dž. *zāsū*: халзан хом шалдан шатны хоёр гуя модонд нарийн уртавтар зөөлөвч эсгий (бамбай) хадаж бэхэлсэн шат.

⁴⁰ Mong. *bambai*; oir. *bambai* [164], *bambā*; хом бамбай; зузаан жийрэг; тэмээ хомноход тэмээний бие, шат модны хооронд барьж зузаалдаг бамбагар зөөлөвч.

⁴¹ Mong. *šang-un örgüge*; oir. *šanggiyin öргеi* [örgē]; *šang* < chin. *shang* «урамшуулан олгох хувь хэшиг, буюу шагнал болгож өгөх юм»; *sang* < chin. *cāng* «хутагт нарын хувин аж ахуй; засаг төр, титэм сан газар» RKWb. 349; mong. *örgüge*, oir. *öргеi*, *örgē* гэрийн хүндэтгэл нэр, гэр өргөө; ноёд ихсийн ордон, байшин сав. [örgege; ör- «тавих өргөх»; > tel. alt. sag, koib. *örgö*, alt. *örgün*] RKWb. 299. Шангийн өргөө: алив чухал, үнэт, алдартай зүйлс хадгалах сангийн гэр. Энэ дацангийн арвин сан = дотоод сан, хутагтын бурхан тахил, мандал, даншиг, өргөл барьц авах, түүнийг хадгалах, мөн хийдийн мал сүрэг зэрэг гадаад сан бадрах санг бүртгэн данслах албаны өргөө гэр.

⁴² *arban teremt* арван ханатай өргөө.

⁴³ Mong. *tuydam*, oir. *duqdam* < tib. *thugs dam* «ордон өргөө» төрийн тугдам, ноёны тугдам, ламын тугдам.

⁴⁴ Mong. *üküg*; oir. *üküg* [164] хайрцгаас том, дээрээ буюу урдаа нээлхий хавхагтай, эд юм агуулах дөрвөлжин модон авдар; хээрлэн явахад бяцхан хүүхдийг агуулж тээх хогшил; *üwkü*, *ükük* Tsoloo, *üküg* D. Ka. 167; авдар, үхэг.

⁴⁵ Mong. *tabiur*; oir. *tabiur*, *tawiür*, *tabiur* [138]; *täwür*, *dorkü*, *dundkü*, *dorkü* D. Kara [161]; эргэнэг, эргүүл, эргүүлэг. Тогоо, шанага, сав суулга зэрэг гал тогооны хогшил тавих дээд, дунд, доорхи гурван тавцан тавиурыг хоёр цах модонд бэхэлж, гэрийн зүүн дордод ханатай баглаж тогтоодог модон тавиур; Бур. *эргэнэг табюур* К. Че. 409, 770.

⁴⁶ Есөн тамгат том тогоо.

⁴⁷ Mong. *toyoyan*, *toyoy-a*; oir. *toyoi* [164] *xāsīn*, *xāsn* «тогоо»; [*qajisun:dekokt qajr-* хайрах, шарах; osm. *qawut*; tü. *qaimaq*, *qaina-*] RKWb. 180.

⁴⁸ Mong. *juuq-a*; oir. *zuuya* [164]; < chin. *zao huo*; *xōwn*, *xōwun gobung* < chin. *houo-p'en* нүүрс ноцоож хөлчөөх сав D. Kara 143; Дотор нь гал түлэхэд зориулсан төмөр зуух (хоовон).

⁴⁹ Mong. *sirbegül*; oir. *širböül*, 1. тогооны алчуур; 2. хогийн шүүр; ширбүүл.

⁵⁰ Mong. *aya-a*; oir. *ayaḡa*, *āḡa* [164]; *āḡ*, *āḡ* D. Ka 127; *āḡa*, *āḡa*, *a'āḡa*; *āḡā* [*ajaya*: tü. *ajaq*, jak. *ajax*; tu. *hāga*, gold. *ajan*] RKWb. 20; аяга.

⁵¹ Mong. *diyiji*, *deyije*, oir. *dīzi*, *diyiji*, *diyizi* [164]; < chin. *diezi* дийз таваг.

⁵² Mong. *dombo*, *dom*, oir. *dombo*; < tib. *dong ma*; Цайны домбо; дээжийн домбо.

⁵³ Oir. *küb* [164]; айраг, тараг, сүү зэрэг цагаан идээний зүйл агуулах модон босоо хувин, ган.

⁵⁴ Mong. *vayar*, oir. *vār* [164]; < chin. *wā*, ваар.

⁵⁵ *čüügün*, *čügün* [138], цай, аршааны данх.

⁵⁶ *köküür*; oir. *arxad* [137]; *arxad ükürān arsār xīsen saw* D. Ka 127; *arxad*, [*arqad*, alt. *arqyt*] RKWb. 14; хөхүүр, айраг, тараг, чигээний хөхүүр.

⁵⁷ Mong. *uyuta*; дунд эртний *hu'utu*; *uyuta*; oir. *uutu* [136]; *outa* J. Krueger 105.

⁵⁸ Oir. *düngkii* [136]; ноос, аргал тээвэрлэх том даавуун уут.

⁵⁹ Mong. *siyudai*; oir. *soudā* [164]; < chin. *shāo dai* үс ноос, аргалын шуудай.

⁶⁰ хошуу

⁶¹ Mong. *keb*; *tamḡa* (*bōrosogiyin*); боорцогийн хэв.

⁶² Mong. *durang*; oir. *durum* [137]; *durā*, *durum*, *durun* Dž. Tsoloo; халь. *дурнав* Б. Му. 216; [*dury*: tü. tib. *durbn*] RKWb. 103:// перс. *dūr* О. Сүх 89; бур. *дурам* К. Че. 202; дуран.

⁶³ Mong. *čisčēü*, oir. *čisčü* [136]; < chin. *zhosi chóu*; чисчүү. Царс модны навчаар тэжээсэн хүрийн ширхэгээр нэхсэн торгомсог бараа.

⁶⁴ Mong. *vadang*; oir. *wādang* [136]; О. Сүхбаатарын бодлоор < chin. *bāodan*, *bāйдань*, *wōдань* юм боож байлах дөрвөлжин бөс. ваадан, гэвч дурдсан гурван хятад үгээс эхний хоёр нь авивзүйн үүднээс монгол *ваадан* гэдгийн эх байж боломжгүй. Уг эл монгол үг манжийн *wadan* гэдгээс гаралтай, тэр бол хятадаас авсан үг болно. Ма. *wadan*.

⁶⁵ Oir. *borōn* [136]

⁶⁶ Oir. *šalkeb* [... 145, 146], kalm. *šalkib* «лавир» (бурханв хөрөг, зураг дээгүүр буюу хойгуур татах хөшиг, асрын дээвэр шиг юм) < tib. *zhal-khebs* RKWb. 354b.

⁶⁷ Oir. *šambu* ? [146]

⁶⁸ Mong. *sebeg*; oir. *sebeg* [136]; < tib. *gzeb* ~ *sig pu*; хулс, бургас, туйван зэргээр сүлжин хийсэн юм агуулах сэгс, сав (сaгс). 21, 27, 36 – тын сэвэг цай гэдэг нь нэг сэгсэн хунзад багтах цайны тоо. Хунз *qunja* < chin. *kuāng zi* хулс, бургасаар сүлжиж хийсэн юм тээвэрлэх, хадгалах авдар.

⁶⁹ Mong. *jing*; oir. *jing* < chin. *jin* [137]; Хүндийн хэмжээний нэгж. Арван лан нэг жин болно. 600 граммтай тэнцэнэ.

⁷⁰ Mong. *yuvayimin* ~ *yoyimong*; oir. *güimin* [137]; < chin. *guamian*; гоймон.

⁷¹ Mong. *lang*; oir. *lang* [137]; < chin. *liang* хүндийн хэмжээ; арван цэн нь нэг лан. Цэн нь *cin* < chin. *qián* лангийн аравны нэг буюу 10 пун, 3.7301 граммтай тэнцэнэ. Пун нь *pin* < chin. *fēn* хүндийн хэмжээ, лангийн зууны нэг буюу 0.37301 граммтай тэнцэнэ.

⁷² Mong. *yüvanbuu*, *yuwangbuu*, *yuwanbuu*; oir. *yembou* [136]; < chin. *yuánbao*. Мөнгөн тэмдэгтийн үүрэгтэй зоос байсан учир лан, жингээрээ өөр, өөр нэр бүхий. Хулгар ембүү 49.50 лан мөнгө; ширээ цагаан ембүү 50 лан мөнгө; дуутуур ембүү 4-5 лан мөнгө; илжигэн туруу ембүү 5 лан мөнгө; тойгон ембүү 10 лан мөнгө (О. Сүх 95). Ембүү, юмбүү.

⁷³ Mong. *jaq-a*; oir. *zax-a* хувцас, хадаг, даавууны тоо, ширхэг; Дөрвөн их хадаг.

⁷⁴ Mong. *qadaq*; oir. *xadaq* < tib. *kha dog*. хүндэтгэлийн ёслолд барих өгөх торгон, мяндсан нэхмэл эд. Даш «өлзийт» сэргэ «сансрыг амарлуулагч» Ходоод, Вандан, Соном (буяны), Аюуш (Аюуш бурханы хөрөгтэй) зэрэг олон ялган нэрлэнэ. 2. Арилжаа наймаанд мөнгийг орлож байсан хэрэглүүр. (О. Сүх 193); хадаг.

⁷⁵ Mong. *sambai*; oir. *samba* [136]; < ? хадгийн анхны нэгж.

⁷⁶ Oir. *bāja* [136]; *bāza*; Багц; бааз; хэсэг, хэсэг, боодол.

⁷⁷ Mong. *kūji*; oir. *kūji* < skr. *kuśa*: нэгэн зүйл анхилам сайхан үнэртэн; зай.

⁷⁸ Ойрдын шашны их ламтан Хутагтын гэгээн (1559–1662) – Намхайжамцын цутгамал дүр мөнгөн шүтээн [1486 156] *xutuqtuyin körög* [150]; *xutuqtuyin öüden* [141]

⁷⁹ 27-р тайлбарыг үз.

⁸⁰ Mong. *yamundaga*; oir. *yamandaga* < skr. *Yamāntaka*; Ямандаг бурхан.

⁸¹ Mong. *jingči* ~ *jangči*; oir. *janči*; ма. *janči*; < tib. *gzang bya* ламнарын нөмрөх олон хуниастай хувцас жанч.

⁸² Oir. *jinkeb neringtei* [140].

⁸³ Mong. *Mayidar*; oir. *Mayidar*; < skr. *Maitreya*, *Maitra* «элэгсэг; ивээл, ээлт», Ирээдүй цагийн бурхан.

Майдар.

⁸⁴ Oir. *souxu burxan* [139] суумал бурхан

⁸⁵ Mong. *šaril*; oir. *šalir* [138]; < skr. *šarira*; шарил; Наваанлуvsанжамбал үндсэн ламтаныг жанч халахад цогцосыг нь хайлуулан алтан суваргад чандарлажээ; *šalir* D. Ka 158; *šälir* нандигнан ариутгасан цогцос RKWb 354.

⁸⁶ Mong. *körög*; oir. *körög*; Намхайжамц хутагтын хөрөг бурхан олдоогүй байна.

⁸⁷ Mong. *Maqagala*; oir. *Maha galayi* [134?]; *Maha-kala* [139]; < skr. *Mahākāla*; Махгал бурхан. Гурван толгой, зургаан мутартай их ид хүчтэй сахиус.

⁸⁸ Mong. *nindar*; oir. *nangdar* [139]; < tib. *snyan dar* «сонорын торго» буюу айлтгалын хадаг; чин сэтгэлээсээ үнэнчээр дэвшүүлсэн, бурханы өмнүүр татах өргөлийн торгон хадган хөшиг.

⁸⁹ Mong. *semdem*; oir. *Sengdongma* [140]; < tib. *seng gdong* «арслан нүүрт».

⁹⁰ Mong. *töge*; oir. *töi* [144]; *yesün töi laqšintai* [144]; есөн төө (1м 80 см) лагшинтай; [144];

⁹¹ Mong. *lašsin*; oir. *laqšin* [144]; < skr. *lakṣaṇa*; Майдар бурханы хөрөгийн биеийн өндөр; Биеийн хүндэтгэл нэр.

⁹² Mong. *toqoi*; oir. *toxoi*; *yesün toxoi zaxačibtai* [144] есөн тохой ~ 3 м 60 см өндөр. Майдар гэгээний хөрөг бурханы зах хөвөө нь 3 м 60 см орчим болно.

⁹³ Mong. *Manjusiri*; oir. *Mañjuśri* [49]; < skr. *Mañjuśrī* «зөөлөн цөгт»; Бурханы шашны дөрвөн их бодисадвын нэг.

⁹⁴ Oir. *Lhamo nökiid selte* [154];

⁹⁵ Mong. *Dar-a*; oir. *dare eke* [144, 157]; < skr. *Tāra*; гэтэлгэгч дара эх, дархи.

⁹⁶ *Kün mkhyen blamayin töröliyin üveyin körög* [157].

⁹⁷ Mong. *Amindabha*, *Amindau-a*; oir. *Amindabha* [163]; < skr. *Amitābha*; tib. *Od-dpag-med* цаглашгүй гэрэлт. Даяны 4-р бурхан Одбагмид. Язгуурын таван бурханы нэг урт насны шид увидас соёрхогч Авид бурхан.

⁹⁸ Oir. *Mila otoči* [163]

⁹⁹ Mong. *tany-a*; oir. *tanga* [139]; < tib. *thang ka*, «хөрөг»; хавтгай (даавуу, зотон мэт) юманд аливаа юмны төрх, дүр байдлыг гарган хийсэн зураг; хөрөг танга.

¹⁰⁰ Mong. *arban jiryuγan batu oran*; oir. *arban zurγān batu oroni yurban körög* [145]; < tib. *gnas brtan bcu drug* «Найдан жүдэг» «арван зургаан батдахуй»; Шагжмуни бурханы 16 шадар шавь. Бурханы шашныг сахина гэж ам авч сэтгэлийн муу дайснаа дарахаар бясалгал хийсэн 16 архадын нэр. (О. Сүх 142, 243)

¹⁰¹ Mong. *gabala*; oir. *kabala* [...139...]; < skr. *kapāla*; хүний толгойн ясны оройн хэсэг; гавал аяга; гавал дамар; гавал эрхи.

¹⁰² Mong. *kusa* ~ *gusa* ~ *güsi*; oir. *güsi* [139]; «мууг арилгагч»; роа cynosuroides. мөнх өвс, өлзийт өвс; Бярманы болон бурхны шашинд бузар түйтгэрийг арилгах зан үйл гүйцэтгэхэд хэрэглэдэг дурваагийн [skr. *dūrva* (> tib. *dur ba*) mong. *dūrva* = ургамал] төрлийн олон үзүүрт навчтай, нарийхан ширхэгтэй, урт иштэй ариун өвс (О. Сүх 73, 92).

¹⁰³ Mong. *bumba*; oir. *bumpa* [139]; < tib. *bumba*, *bum pa* «ариун усны сав»: их эрдэнийн баян бумба. Өлзийт найман тэмдгийн нэг.

¹⁰⁴ Mong. *čögüče*; oir. *cögiücö* [...139...]; зул барих тахил тавих зэрэгт хэрэглэх нэгэн зүйл жижиг аяга; [*tsöktšö, tsöktšü äyā* (= *sart čöwč - aq*) kkir. *čöčak*, alt. *čöčü*]; RKWb. 432; бур. *сүгэс* К. Че. 398.

¹⁰⁵ Нэг эгнээ, нэг мөр цөгц = 7 ширхэг цөгц.

¹⁰⁶ Mong. *bayitu*; oir. *bayitung* [146]; < chin. *bāitōw* зэс, цайрын холимог цагаавтар цөгц; Юманд дэвсгэр үндсэн өнгө болгож холих, түрхэх нэг зүйл цагаан юм, будаг.

¹⁰⁷ Oir. *γoltu* [163]; нэг эгнээ, нэг мөр цөгцийн голын том цөгц; зулын том цөгц;

¹⁰⁸ Mong. *mandal*; oir. *mañdal* [156, 148]; < tib. *ma ṅdala*; < skr. *mañdala*; Бурхан, лам зэрэгт өргөх тахил, тавиглал. Ачлах мандал өргөв [148].

¹⁰⁹ Mong. *serjim*; oir. *serjem* [...139]; < tib. *gser sgyims* «алтан ундаа»; Бурхан, тэнгэр, газар, лус тайх, жич сацалд өргөх архи, цайны зүйл.

¹¹⁰ Mong. *manday-a*; oir. *mañdai* [150]; < tib. *mañda*. Шашны ёсны тахил тавигийн дугуй суурь.

¹¹¹ Mong. *saγuri, saγudal*; oir. *čoačen xuruliγin söür* [139, 140]; залбирал, уншлага голлосон их чуулган ном хурах гол дуганы суудал, суурь.

¹¹² Mong. *labri*; oir. *labrei, labre* [...140, 146] [163]; < tib. *bla bre*. Гэр өргөөний хойморийн шүтээний өмнүүр хөндлөн ташаалан татсан хөшиг; Бурхад, хувилгаад, ламнарын суух суудал нэгэн зүйл чимэг хэрэглэл (О. Сүх);

¹¹³ Oir. 3 *nomto xubčün* шашны их хурлын үед өмсөх хүндэтгэлийн хувцас, дээл. Гурван номт дээл нь: 1. Лагай *layai*; tib. *bla gos* «дээд хувцас»; Бурханы шашны гэлэн хүний гадуураа өмсөх улбар шар өнгийн тэрэмэн даавуугаар хийсэн номт хувцас; 2. намжар, *namjar*; ламнарын хурал хурах, ном унших зэрэгт өмсдөг тоо тогтоол бүхий хэсэг бөсөөр зүйж хийсэн шар хүрэм буюу карша дээл. Mong. *karsa ~ γarša, γarš-a, γarsay-a* < skr. *kāshya* аяга тэгимлигүүдийн гадуур өмсөх ал шар торгон хувцас; Аяга тэгимлиг *ayaγ-a takimlig* < ui. *ajaγqa tekimlig* «хүндтэй шүтээн»; Бурхны шашны ёсонд хоёрдахь удаагаа сахил хүртсэн гэлэн санваартан «аягаар гүйцэтгэгч»; Бас бурхан шашны гэлэн хүний орхимж мэт нөмрөх нэгэн зүйл давхац хувцас; *namdžir, namdžar*, дээл, нөмрөг; *tsög, ködrge = namdžär, «mantel»* RKWb. 271; 3. таншин, таншим: *tangšam* tib. *tang them* «доод хувцас»; Лам нарын өмсдөг хүрэн тэрэмээр хийсэн банзал хэлбэрийн хувцас; *tañšim* хэлбэр байдал өргөн хувцас, дээл. RKWb. 379,80. Г. И. Рамстедт халимаг хэлний *tšög*-ийг «дээл, нөмрөг». *ködrge, namdžir, zantši*-тай ойролцоо утгатай (Г. Рамстедт. 445) гэсэн чойго, чого *čoga* < tib. *cho ga* «ёс зан үйл», *chos gos* «номын хувцас». Ойрадын *čög* бол төвдийн *chos gos*-той холбоотой байх (Д. Кара). Гэлэн хүний биеэсээ салгахгүй авч явдаг зүйл, түүнд 1. лагай, 2. намжир, 3. таншин хувцасны бяцхан дүрс хийнэ... (О. Сүх 215).

¹¹⁴ Mong. *talbay*; oir. *talbaq* [157] гадар татаж хийсэн орны дэвсгэр; гудас; *džurüm Dz, talbuk, talwuk* U. D. Kara [160]; талбар.

¹¹⁵ Mong. *tüsilge*; oir. *tüšilgü* [...139...]; олбог түшлэг; арын түшлэг; гарын түшлэг.

¹¹⁶ Mong. *büriy-e, bürege*; oir. *bürei* [141] шашны зан үйлийн хөгжим; *bürü [bürege, ükr b; kom. bürgü]* RKWb. 67; бур. *бүрьеэ* К. Чер. 123. бүрээ.

¹¹⁷ Mong. *biskigür*; oir. *bišigüür* [141] бишгүүр.

¹¹⁸ Mong. *qongq-a*; oir. *xongxo* [139]; [tib. *drib-bu*] Дуу чимээний хүчний билгэдэл; Дуу чимээний хүчээр шүтээн бурхан, хүссэн зүйлсээ урин ирүүлдэг; *хоңхā [alt. qoŋo «хонх»]* RKWb. 186 хонх.

¹¹⁹ Mong. *damaru*; oir. *damar* [139]; < tib. < skr. *damaru*; сатуур хэнгэрэг; Сав, шим хоёр ертөнц хоёр тийш харж оршино гэсэн бурхны шашны номлолыг билгэдсэн, (утас буюу хивээр оосорлосон, хоёр товчин цохилууртай) хоёр талыг ширлэсэн шашны зан үйлд хэрэглэх хөгжимийн зэмсэг. *damr, dambr* RKWb. 75, 76; *дамару* К. Че. 19; дамар.

¹²⁰ Mong. *čang*; oir. *cang* [139] *chang* [149]; *tsaŋ [kas. čaŋ, хонх; šor. šaŋ «хонхон»]* RKWb. 421. цан.

¹²¹ Mong. *dung*; oir. *dung* [139]; *düŋ* [148] < tib. *dung*; дун; лавай. Яруу цуурайт цагаан лавай, дун.

¹²² Mong. *yangling*; oir. *gangling* [139]; < tib. *rkang gling* чөмгөн лимбэ; Голдуу 18 настай эмэгтэй хүний чөмгөний яс эсвэл зэсээр хийсэн луу, бас матрын толгойн сийлбэртэй, 50-60 см урт, шашны хурал номын зан үйлд үлээж хэрэглэх бишгүүр хөгжим; *gañin* RKWb. 144; ганлин.

¹²³ Mong. *kenggerege*; oir. *kenggerег* [140]; цохих хөгжимийн зэмсэг, дүгрэг цагирагийн хоёр этгээдийг арьсаар бүрж хийнэ; *kengrge* бөмбөр, хэнгэрэг [*čag. käürgä «бөмбөр»]* RKWb. 226; хэнгэрэг. Uig. *kängsäk*.

¹²⁴ Mong. *včir qongg-a*; oir. *očir xonggo* [163] ui. *včir* < skr. *vajra*. Хоёр талд тав, таван үзүүр гаргаж хийсэн, ном хурахад хонхтой хамтаруулан хэрэглэх нууц тарнийн увидастай хөгжимийн зэмсэг. Дуу чимээний билгэдэл хонхыг зүүн гартаа, чимээгүйн хүчний билгэдэл Очирыг баруун гартаа барина. Хонхын дуунаар шүтээн бурхан, хүссэн зүйлээ урин ирүүлдэг бол Очирын дохилтоор сайныг тогтоон мууг хөөн зайлуулдаг. Очирын үзүүрүүдийн уулзвар задгай бол догшин, битүү бол амарлингуй гэнэ. (О. Сүх 152); *wičir, vičer* Dz, U; *wašr* O (= *otšr, batšr*) RKWb. 462. Очир хонх. Хонх бол билиг, очир нь аргын бэлэг тэмдэг (Д. Кара).

¹²⁵ Mong. *jangčan*; oir. *žalčín* [154] *jalcan* [163], *jalchan*; < tib. *rgyal mtshan* «ялгуусны тэмдэг»; (skr. *dvaja*); дуаз; хурал номны газар, сүм дуганд байдаг бурхны шашны ялгуусны туг тэмдэг. Жанцанг гол төлөв шармал зэсээр хийж, гадна талд нь элдэв дүрс товойлгон гаргадаг. Мөн ногоон, шар, цагаан, улаан, хөх зэрэг олон өнгийн даавуу бөсөөр ч хийдэг. Сүмийн оройд эсвэл дээврийн дөрвөн өнцөгт босгодог жалчин.

¹²⁶ Mong. *kei mori*; oir. *kei mörni jalchan* [146]; морь унасан хүний зурагтай нэгэн зүйл «ялгуусаны тэмдэг» дарцаг; *kimör*, *kimir lündä*, *kī mör*, *mör kišig* «сайн сайхан, аз жаргал» [*kei* > alt. tel] RKWb. 233,34, 266; хийморийн дарцаг.

¹²⁷ Mong. *šaser*; oir. *šaser* [149] < tib. *zhwa ser*; «шар малгай»; монгол гутлын дотуур углах эсгий оймс хэлбэртэй, дээрээ цацагтай, ардаа залаатай, их сүмийн хүрал, их ёслолын үед өмсөх малгай; *šašar*, *šašir malxā* Tsoloo; *šasr maxlā*, *deltē maxalā* RKWb. 351, шашар малгай.

¹²⁸ Mong. *baγan-a*; oir. *conduq* [139], *baxana* [150]; байшин, сүмийн багана; *tsongdag* (Ö) багана, шон, G. Kara 129; [*čoydag*; šor. *čoydag* багана, шон] RKWb. 430.

¹²⁹ Mong. *erike*; oir. *erken* [140]; тарни урихад хэрэглэх эрихэ; гавал эрихэ; 108 хүний толгойн яснаас нэг нэг бөөрөнхий яс авч хийсэн ясан эрихэ; [ma. *erixe*; *erke*, *erkn*] RKWb. 125; эрх.

¹³⁰ Oir. *banggeb* [140]; < tib. *pang khebs* (*Bad ngya*... I/ 238b II/ 609a хормогч.

¹³¹ Mong. *silnen*; oir. *silnen* [141]; < tib. *sil-snyu* «яруу хөгжим, дэлдэх хөгжим»; Цан хөгжимтэй баахан төстэй авч, бариул нь цангийнхаас том, хүрээ дэрэвгэр, дотор талд нь маанийн үсэг байдаг (O. Сүх 175); *selnen*(ō) хонх, янчир (*zimbel*) RKWb. 323.

¹³² Mong. *qorlo*; tib. *khoro*; хаан төрийн долоон эрдэнийн нэг, төр улс, айл гэр, хүн ард нь. Номын гэрлээр гийгүүлэгдэн юунд ч дийлэгдэшгүй бат байхын билэгдэл; хорол.

¹³³ Mong. *sikür*; oir. *šükür* [157] Бурхандаа өлзий сайныг билгэдэн өргөдөг найман тахилын нэг эрдэнийн цагаан шүхэр; [*sükür*; otü. *šökür*, *šögür*, нарны шүхэр] RKWb. 370; шүхэр.

¹³⁴ Mong. *čečeg*, *sečeg*; oir. *ceceq* [.145.], үнэнч шудрагын цагаан лянхуа цэцэг. *linggu-a* < chin. *lianhua*; Усанд ургах олон наст, цэцэг нь гүн улаан, цайвар улаан, цагаан өнгөтэй, үнэр анхилам өвслөг ургамал, өлзийт найман тэмдгийн нэг; цэцэг.

¹³⁵ Mong. *altan migtür migman sba*; tib. *mig-thur mig-smān sba* нүдний халбаг, нүдний эм.

¹³⁶ Oir. *dingkeb* [150], *dinkeb* [163]; < tib. *rten khebs* «шүтээний хучлага алчуур».

¹³⁷ *nīdan* ?

¹³⁸ Oir. *nīdan kang bürēsütei* [154, 56] нийдан кан бүрээстэй.

¹³⁹ Oir. *pan* [163]; tib. *phan* залаа, тууз, унжлага.

¹⁴⁰ Oir. *nīndar* [140, 148]; tib. *gyan dar*; «Хишгийн торго»; Сайн сайхан, энх эсэн, урт наслахын билэгдэл болгосон цагаан өнгийн нэг зүйл алчуур.

¹⁴¹ Mong. *čoyijil*; oir. *coyijil*; < tib. *chos rgyal*; «номын хаан»; Тамын орын эзэн эрлэг номун хаан. Нэг гартаа толь, нөгөө гартаа жигнүүр бариад тамд очсон амьтны нүгэл хилэнцийг харж, дэнсэлж халуун хүйтэн тамын аль нэг үрүү шиддэг гэж домогт сахиусны баг.

¹⁴² Mong. *yangyoi*; oir. *nīndar yangyoi* «хишгийн нэг зүйл эрэн торго».

¹⁴³ Mong. *günyarqba*; < tib. *kun dga 'ra ba* «хотол баясгалаг хүрээ»; Бурханы ном, шүтээн, тахил, залж агуулах модон хайрцаг.

¹⁴⁴ Oir. *kangjai* [139], *nīndar gangjai* [140].

¹⁴⁵ Mong. *kasiga* (O. Ков.); oir. *bkā-šoq* [139]; < skr. *kāśika*; кааши (Варанаси)-д хийсэн нарийн нэхмэл; ёрог.

¹⁴⁶ Mong. *sirege*; oir. *širē*; *širei* [138], *morin širei* [139], *takiliyin širei* [149], *Mandaliyin xoyor yeke širei* [156], *damjuur širei* [156, 163]; *širē* D. Dz, *širē* U. D. Ka. 159; *širē* [> osm. čag. kom. *šird*, šor. sag. *sirā*] RKWb. 359.

¹⁴⁷ Oir. *tabjur* [164].

¹⁴⁸ Mong. *γajar*, *talbai*; oir. *oron*; *oron tāraling* [= *tarāling* 150, 151, 164]; *tsangān orām* Dz. Тариаг мориор (үхэр) гишгүүлэн цайруулхаар зассан талбай; *buxān orām*: суваг, шуудуу, бухын улбаа; *orm* «талбай, газар; тэмдэг; мөр, ул мөр»; [*oram*, *orun*, kir, čag, *oram* «хороолол»; alt. tel. *orom* «тэмдэг»] RKWb. 289; орон тариалан орон газар «эээмшихүүн» Дре.т.ю.слов. Л. 1969:282.

¹⁴⁹ Oir. *tārig* тариалангийн талбай, тариалах газар; *tarān*, uig. *tary-γ*, тариалангийн газар, kas. kir. kom. *tary*, шар будаа амуу; alt. tel. *tarān*, bar. *tarān* RKWb. 380.

¹⁵⁰ oir. *činalya*, *nege sarā činalya örgübei* (нэг сарын цав өргөв) [160]; цавын будаа; цагаан цав; *tsaw*, *tsab*. RKWb. 423.

¹⁵¹ Mong. *manji*; oir. *manza* [141]; < tib. *mang ja* «олны цай», шашны хурлын үеэр гэлэн хуврагуудад өгдөг цай, манз ч гэнэ. Манз цав: *čaba*; < tib. *tsha ba* «халуун хоол»; Лам хуврагийн хоол; *manza* (Ö) RKWb. 256.

¹⁵² Mong. *jed*; oir. *gyed* [156]; өглөгийн эздээс сүм хийдэд өргөсөн зүйлийг шашны ёсны хурлын ламнарт барих түгээл; *zed* «өглөг, бэлэг» RKWb. 471.

Ном зүй

- AE – *The History of a Jakhachin Buddhist Monastery. Dharmabadra's „Golden Rosary”*.
Facsimile edited and introduced by G. Kara and J. Tsoloo. (Debter 12) Budapest 1997
- Bawden, Charles: *Mongolian-English Dictionary*. London 1997
- Birtalan, Ágnes: Geschichte der heiligen Götterbilder der drei Klöster unseres Ĵaqačin Volks. In:
Acta Orientalia Hung. XXXIX (1985), pp. 177-203
- Bod Rgya tshig-mzod chen-mo*. Beijing 1985
- Coloo, Ĵ. (ed.): Biography of Caya Pandita in Oirat Characters. In: *Corpus Scriptorum Mongolorum* V., Ulaanbaatar 1967
- D. Ka. – Kara, G.: Notes sur les dialectes Oirat de la Mongolie occidentale. In: *Acta Orientalia Hung.* VIII (1958), pp. 111-168
- DĴ. Tsoloo – Цолоо, Ж.: *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь II. Ойрд аялгуу*.
Улаанбаатар 1988
- Kara György: *Mongol-magyar szótár*. Budapest 1998
- Krueger, J. R.: *Materials for an Oirat-Mongolian to English Citation Dictionary I-III*.
Bloomington 1978, 1984
- Mostaert, A.: *Dictionnaire Ordos I-III*. (Monumenta Serica Monograph V) The Catholic
University, Peking 1941-1944
- RK Wb. – Ramstedt, G. J.: *Kalmückisches Wörterbuch*. Helsinki 1935
- Sárközi, A. – Szerb, J. (eds.): *A Buddhist terminological dictionary, the Mongolian Mahāvvyutpatti*. (Asiatische Forschungen 130) Wiesbaden 1995
- Vietze, H.-P.: *Wörterbuch Deutsch-Mongolisch*. Leipzig 1987
- Б. Му. – Муниев, Б. Д. (Мунин Бембе): *Калмыцко-русский словарь*. Под редакцией Б. Д.
Муниева, Москва 1977
- Д. Гон. – Гонгор, Д.: *Халх товчоон II*. Улаанбаатар 1984
- Дре.т.ю.слов. – *Древнетюркский словарь*. Ред. В. Наделяев – Д. Насилов – Е. Тенишев – А.
Щербак, Ленинград 1969
- К. Че. – Черемисов, К. М.: *Бурятско-русский словарь. Буряад-ород словарь*. Москва 1973
- О. Ков. – Ковалевский, О.: *Монгольско-русско-французский словарь. I-III*. Казань 1844-1849
- О. Сүх. – Сүхбаатар, О.: *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар 1997
- Пүрэвжав, С.: *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*. Улаанбаатар 1978
- Ринчэн, Б.: *Монгол Ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас*. Улаанбаатар
1979
- Срав. слов. – *Сравнительный словарь тунгусо-манчжурских языков. I-II*. Ленинград 1975,
1977
- Цэвэл, Я.: *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар 1966

Товчилсон үгийн тайлбар

mong.	монгол бичгийн хэл
oir.	ойрад бичгийн хэл, тод монгол бичиг
D	дөрвөд
Dz	захчин
T	торгууд
U	урианхай
Ö	өөлд
tib.	төвд
skr.	санскрит, эртний энэтхэг хэл
chin.	хятад
kkir.	киргис
ma.	манж
karg.	карагас (түрк)
kas.	Ижил мөрний тэндэх татар
kir.	хасаг
alt.	Алтайн түрк
tel.	тэлэүт (түрк)
tü.	түрк, нийтийн (балар эртний, дээр үеийн) түрк
jak.	саха, якут
gold.	нанай
халь.	хальмаг хэл
бур.	буриад хэл